



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл  
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН  
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Лхагва гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-15

---

1. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	4-15
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын  
хороодын 12 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 55 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 52.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Б.Заяабал;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Лүндэг, М.Мандхай, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа, Ж.Чинбүрэн, Д.Энхтүвшин;  
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Пүрэвдаваа;  
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Г.Ганбаатар, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга.

**Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, С.Замира нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хууль зүйн зөвлөмжийг хэлэлцсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Байнгын хорооны дарга Н.Наранбаатар танилцуулав.

*“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтыг үндэслэн хураах санал/*

**Н.Наранбаатар** 1.Төслийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18  
Татгалзсан: 13  
Бүгд: 31  
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 36 минут үргэлжилж, 55 гишүүнээс 31 гишүүн хүрэлцэн ирж, 56.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 11 цаг 11 минут

### ТӨСВИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Төсвийн болон БОХХАА-н байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 50.9 хувьтай бүрдсэн тул 2025 оны 12 сарын 10-ны өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

7 дугаар тойрог Нанзадын Наранбаатар ирсэн, 11 дүгээр тойрог Норовын Алтанхуяг ирсэн, 3 дугаар тойрог Тилиеуханы Аубакир ирсэн, жагсаалтаар сонгогдсон Ренчиндоржийн Батболд ирсэн, жагсаалт Жамбын Батсуурь ирсэн, жагсаалт Хөххүүгийн Болормаа ирсэн.,9 дүгээр тойрог Жамбалын Ганбаатар ирсэн, 4 дүгээр тойрог Цэрэнпилийн Даваасүрэн ирсэн, 11 дүгээр тойрог Пүрэвжавын Сайнзориг ирсэн, жагсаалт Баатаржавын Мөнхсоёл ирсэн, 2 дугаар тойрог Загджавын Мэндсайхан ирсэн, 11 дүгээр тойрог Чинбатын Номин ирсэн, 2 дугаар тойрог Банзрагчийн Түвшин ирсэн, 1 дүгээр тойрог Ганзоригийн Тэмүүлэн ирсэн, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа ирсэн, 1 дүгээр тойрог Даваагийн Цогтбаатар ирсэн, 2 дугаар тойрог Баттогтохын Чойжилсүрэн ирсэн. Далайн Батбаяр 5 дугаар тойрог.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулъя.

Гуравдугаар тойрог Буланы Бейсен ирсэн, 11 дүгээр тойрог Наранцэцэгийн Алтаншагай ирсэн, жагсаалт Пүрэвийн Батчимэг ирсэн, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг ирсэн, жагсаалт Сонгобайн Замира ирсэн, 9 дүгээр тойрог Жаргалсайханы Золжаргал ирсэн, 6 дугаар тойрог Цагаанхүүгийн Идэрбат ирсэн, 7 дугаар тойрог Цагаанхүүгийн Мөнхбат ирсэн, жагсаалт Баатаржавын Мөнхсоёл, жагсаалт Салдангийн Одонтуяа, 6 дугаар тойрог Ухнаагийн Отгонбаяр, жагсаалт Болдын Уянга ирсэн.

Байнгын хорооны хамтарсан хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя аа.

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж санал дүгнэлтээ чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна аа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё оо.

Нэг асуудал хэлэлцэнэ ээ.

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг ороорой.

Бадамсүрэн ХХААХҮ-ийн сайд, Бадамсүрэн сайд Засгийн хуралд байгаа юм уу сайд байхгүй байна. Бусдыг нь танилцуулж байя. Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ ХХААХҮЯ-ны ГТБХЗГ-ын дарга, Чойдоржийн Чимгэрэл ГЕГ-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч сайдаас бусад нь байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн та бүхэнд тараасан. Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан суулт асуух гишүүн байна уу? Сайд орж ирлээ. Гол нь ажлын хэсгээс танилцуулах танилцуулга байхгүй. Шууд гишүүд нэрсээ өгөөд асуултаа асуугаад явна аа. Тэгээд ажлын хэсэг хариулна нэрсээ өгөөрэй.

Сайнзориг гишүүнээр тасалъя аа. Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Хурал эхлэхээс өмнө нэг зүйлийг хэлье ээ. Өнөөдөр хамтарсан Байнгын хорооны хурал 10 цагаас байсан 11 цаг 10 минут орчимд ирц бүрдэж нэг юм хуралдах гэж байна.

Ер нь цаашдаа аль аль намын энэ Улсын Их Хуралд суудалтай намуудын бүлгүүд энэ ирц дээрээ анхаарч энэ Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах бүтээмжтэй ажиллах энэ бололцоог бүрдүүлмээр байна. Эрт ирсэн хүнтэй хүмүүс нь ингээд сууж л байдаг. Тэгээд орж ирсэн хүмүүс бараг л ирцэд орж байгаагаа алга таших нь холгүйгээр нэг ийм хурал эхэлж байна шүү дээ. Үгүй ээ энэ тоглоом биш. Тэгээд энэ гишүүдийн гадаад томилолтын асуудал сар болгон олгож байгаа хууль тогтоомжийн боловсруулах сурталчлах болон тойрогт ажилладаг мөнгийг нь ирцтэй уямаар байна.

Энийг Улсын Их Хурлын дарга, холбогдох Байнгын хорооны удирдлагууд анхаараач. Ийм байдлаар ингэж бие биедээ ингэж хүндэтгэлгүй хандах энэ асуудлыг зогсоох ёстой. Үнэхээр өвчтэй бол өвчтэй гээд л, гадаад томилолттой бол гадаад томилолттой энэ зүйлүүдээ ингээд явахгүй бол нэг хэдэн ажилгүй хүмүүс өглөөнөөс хойш сууж байгаа юм шиг ийм байдалтай энэ Улсын Их Хурал чинь явж байна шүү дээ.

Тэгээд энэ хоцорч байгаа хүмүүсийн энэ хоцролтын хэмжээнээс нь хамаараад тэр гадаад томилолтоор явуулах эсэх асуудлыг нь шийддэг, орон нутагт ажиллах эсэхийг нь шийддэг, дээрээс нь энэ сар бүр олгож байгаа тэр хууль тогтоомжийг сурталчлах, боловсруулах, энэ тойрогт ажиллах мөнгийг нь эндээс нь уялдуулж хасдаг баймаар байна. Энийг хурал эхлэхийн өмнө зайлшгүй хэлэх хэрэгтэй байна аа.

Энэ зөвхөн манай Байнгын хороон дээр биш нийтлэг. Тэгээд энүүгээр чинь ингээд төрийн захиргааны байгууллагынхан хүлээж байна гээд л 2, 3 цаг хийцгүүрээд коридорт зогсоод кофе шопод л эргэлдээд байж байна. Энэ чинь цаана төрийн ажил гацаад зогсоод байгаа байхгүй юу. Ингэж явж болох юм уу? Нэг дүгээрт энийг нэг хэлчихье ээ 2 дугаарт би яах вэ иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор ажлын хэсгээс хариулаасай гэж бодож байгаа юм. Энэ зун зуншлага бол нийт улсын хэмжээнд тааруухан байсан. Ялангуяа баруун аймаг руу ерөнхийдөө зуншлага үнэхээр муу байсан. Энэнтэй холбоотой ган зуд болох эрсдэлүүд байна. Тодорхой хэмжээнд энэний бэлтгэл ажилтай холбоотойгоор холбогдох институцүүд бэлтгэл ажлыг хангаж байгаа байх. Улсын нөөцдөө авсан өвс тэжээлийн фонд нөөц ер нь баруун аймаг тийшээ зохион байгуулалтын хувьд болоод нөөцийн хэмжээ ямархуу байгаа юм. Тэр чиг рүү өвсний үнэ ханш нэг пресс нь хэд хүрч байна. Яг малчид малаа зах зээлд нийлүүлэх ажлыг ямархуу бодлого зохион байгуулалтаар та бүгд дэмжиж ажиллаж байна? Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас. Энэ зүйлүүдийг нэг тодорхой хариулаач.

Хоёрдугаарт энэ тогтоолд нэмэлт орж оруулж өгч байгаа энэ тогтоол маань малчид болон ААН байгууллагууд ямар боломжийг гаргаж өгч байгаа билээ? Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай аймгаар. Тэжээлийн эрдэнэ шиш болон үр тариа болон буурцагт ургамлыг шигших тээрэмдэх эсвэл бусад боловсруулалтын явцад гардаг хорголдсон эсвэл.

**Н.Наранбаатар:** Сайнзориг гишүүн нэг минут нэмж өгье.

**П.Сайнзориг:** Хивэг болон бусад үлдэгдлийг ингээд импортлох боломж гарч ирж байна аа. Энэний бололцоо ер нь зүгээр нөхцөл байдал болон хугацаа энэ зүйлүүдийг нэг иргэд олон нийтэд нэг мэдээлэлжүүлэх үүднээс яг энэ эцсийн хувилбар дээр албаных нь нэг байр сууриа хэлээч ээ. Тэгээд ер нь цаашдаа уг асуудлыг уг нь нэг байнгын шинжтэй болгоод явчих хэрэгтэй юм шиг байгаа юм. Үе үе ингэж орж ирээд биш. Яг ийм нөхцөл байдал үүслээ гэхэд тэр хуулийн заалт шууд сэргэж хэрэглэгдэх бололцоотой байдлаар ингээд явчихмаар байгаа юм аа. Тэгээд энэ чиглэлдээ нэг цаашдаа хэдүүлээ анхааръя. Тэгээд тодорхой албаны байр суурь, өвөлжилтийн бэлтгэл ажил, ер нь зүгээр хүндрэх нөхцөл байдлууд юу байна урьдчилсан байдлаар ямархуу нөхцөл байдалтай байгаа вэ гэдэг талаар мэдээлэл өгөөч.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Бадамсүрэн сайд хариулъя.

**М.Бадамсүрэн:** Та бүхэнд энэ өглөөний мэндчилгээ дэвшүүлье ээ. Сайнзориг гишүүний 2 асуултад хариулъя аа. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар Засгийн газраас 56 дугаар тогтоол гаргасан байдаг. Тэгээд энэний явц хэрэгжилтийг өнөөдөр Засгийн газрын хуралдаанд сая танилцуулаад Засгийн

газрын хуралдаанаас миний бие гарч ирлээ. Энд бол 94 хувиар энэ төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан гэсэн дүн байгаа.

Хоёрдугаарт таны асуусан малчид иргэдэд ямар энэ гурил тэжээлийн импортыг баруун бүсэд бууруулснаар, хөнгөлснөөр чөлөөлснөөр ямар үр дүн гарах вэ гэдэг асуултад хариульъя.

Баруун бүсийн 5 боомтоор гурилыг 15 хувийн татвартай байсныг тэг хувь болгох, тэжээл мөн 5 хувийн одоо татвартай байсныг тэг хувь болгох ийм Засгийн газрын тогтоолын төслийг бид боловсруулсан байгаа. Хэрвээ Улсын Их Хурлаас энэ Баруун бүсэд гурил тэжээлийн импортыг зохицуулалт хийх эрхийг хөнгөлөх чөлөөлөх эрхээ Засгийн газарт өгсөн шийдвэр гаргаж өгсөн тохиолдолд бид Засгийн газраар тогтоол гаргуулахдаа татварыг тэглэе ээ гэдэг ийм саналыг оруулна.

Баруун бүсэд болон төвийн бүсэд зуншлагын байдал хамгийн тааруу байсан 2 бүс байгаа. Тэгээд тийм учраас баруун бүсэд 1 дүгээрт зуншлагын байдал тааруу байсан.

Хоёрдугаарт төвөөс нэлээн алслагдмал тээврийн зардал өндөртэй.

Гуравдугаарт баруун бүсэд тариалангийн үйл ажиллагаа бараг явагддаггүй. Мөн гурилын үйлдвэр байхгүйтэй холбоотой баруун бүсийн аймгуудад гурил тэжээлийн үнэ өндөр байгаа. Ялангуяа Монгол Улс ийм өргөн уудам баруунаас зүүн тийш асар уудам нутагтай учраас төвийн гурилын үйлдвэрээс баруун бүсэд хүргэхэд зардал их өндөр байдаг учраас бүс нутгийн онцлогт тохирсон ийм татварын бодлогыг зохицуулалт хийх эрхийг Засгийн газарт өгөх ийм тогтоол гаргаснаар бол баруун бүсэд гурил тэжээлийн үнэ ААН иргэдэд малчид орон нутгийн иргэдэд бол хамгийн ээлтэй байдлаар очно оо гэдэг ийм тооцооллыг хийж энэ тогтоолын төслийг Улсын Их Хурлын 64 гишүүн Баян-Өлгий аймгаас сонгогдсон Жангабыл гишүүний бланкаар 64 гишүүн саналыг Засгийн газарт хүргүүлсний дагуу Засгийн газар энэ тогтоолын төслийг санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд өнөөдөр ингээд хэлэлцээд явж байгаа гэдгийг танд танилцуулъя аа.

Мөн өвөлжилтийн бэлтгэлийн хүрээнд нэг анхаарал татах асуудал нь малыг эдийн засгийн эргэлтэд оруулах зүйл байгаа. Тэгээд энэ онд Бүгд найрамдах Узбекистан улс, БНХАУ руу 103 мянган толгой малыг амьдаар нь экспортод гаргасан байна. Мөн энэ оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 59 ААН 305.3 сая ам.долларын өртөг бүхий 75 мянган тонн мах махан бүтээгдэхүүнийг гадаадад экспортолсон нь өмнөх жилүүдээс нэлээд өндөр үзүүлэлт байгаа.

Өөрөөр хэлбэл малчдын орлогыг нэмэгдүүлэхэд экспортыг дэмжиж доллар Монгол Улсад орж ирэхэд энэ бодлого үр дүнгээ өгөөд явж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье. Ер нь малчид маань ч гэсэн малаа эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэл рүү илүү анхаардаг болсон. Өөрөөр хэлбэл өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд өөрсдөөс шалтгаалах зүйлүүдээ хийж ажиллах ийм нөхцөл нэлээд нэмэгдэж байгаа гэдгийг бас хэлье ээ.

**Н.Наранбаатар:** Тодруулах уу Сайнзориг гишүүн.

Дараагийн гишүүн Мэндсайхан гишүүн асуулт асууя.



**З.Мэндсайхан:** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг дэмжиж байгаа. Энэ жил ер нь баруун аймгууд маань зуншлага тааруу болсон, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй, ер нь зудын эрсдэл өндөр байна аа гэж үзэж байгаа. Тэгэхээр ингээд аливаа асуудлыг ингэж цагийг нь тулгаж оруулж ирээд ингэж шийддэг энэ Хөдөө аж ахуйн яамныхан УОК-ынхон анхаармаар байна аа. Зун бол одоо зуншлага тааруу байсан нь үнэн. Тэгээд энийг мэдсээр байж ингээд яг өвөлжилт яг хүндэрч байгаа үеэр ингэж тулгаж оруулж ирдэг. Энэ урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ та бүгд маань авч болдоггүй юм уу? Энэ асуудлаа 8, 9, 10 сард аваад явчхаж болохгүй байсан уу, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ төрийн бодлого тогтвортой байх хэрэгтэй байна. Баруун бүс нутагт гурил тэжээлийн үйлдвэр байгуулъя ялангуяа тэжээлийн үйлдвэр байгуулъя гээд АХБ-ны санхүүжилтээр усалгаатай газар тариалангийн төслийн хүрээнд төслийг би сайдаар ажиллаж байхдаа аль 2000 онд эхлүүлсэн. Тэгээд Ж.Энхбаяр сайд энэ бүгдийг очоод байхгүй болгосон. Үр дүнд нь бид нар өнөөдөр тэжээл импортоор авна аа гээд сууж байна. Баруун бүс нутагт тэр дундаа Ховд, Увс бол газар тариалан тэжээлээ тариалаад явах бүрэн боломжтой. Тэнд элеваторын асуудлыг нь шийдээд өгсөн. Тэр асуудал дууссан уу? Тэгээд тэр тэжээлийн үйлдвэр яагаад алга болчхов оо? Одоо өвөлжилт хүндэрнэ. Нөгөө муу хэдэн малчид маань малаа туугаад тусгай хамгаалалттай газар эмнэлгийн үйлчилгээ хүрэхгүй газруудад ингээд малаа маллаад малынхаа эрхээр яваад өгнө өө. Хэдэн малаа онд оруулах гээд. Энэ дээр тэр иргэдийн маань эрүүл мэндийн асуудал эмнэлгийн үйлчилгээг та бүгд маань энэ УОК-т зохион байгуулж байгаа юу.

Ер нь энэ тал дээр хэр анхаарч байгаа вэ? Мөн малын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой энэ малын гоц халдварт өвчний чинь тархалт нэмэгдэнэ ээ. Энэ дээр та бүгд маань мал эмнэлэг урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна аа? Энэ талаар хариулт өгөөч.

**Н.Наранбаатар:** Хариул ажлын хэсгийн 5 дугаар микрофон, Бадамсүрэн сайд.

**М.Бадамсүрэн:** Мэндсайхан гишүүнтэй санал нэг байна аа. Ер нь бодлогын хувьд тогтвортой байх ёстой, төрийн бодлогын залгамж холбоо. Баруун бүсэд усалгаатай газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр өмнө авчирч ирж байсан арга хэмжээ болон тэжээлийн үйлдвэр 80 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байгаа. Энэ асуудлыг судалж шаардлагатай бол газар дээр нь ажиллаж энэ зүйлүүд дээр танд тусгайлан хариулт өгье өө. Улсын Их Хурал 6 сард хаврын чуулган өндөрлөхөөс өмнө гурилын импорт, тэжээлийн импортын татварыг буцааж сэргээх буюу 2024 онд тэглэсэн хуулийг өөрчлөх энэ зүйлийг баталсан. Тэгээд энэнээс хойш Улсын Их Хурлын гишүүд 64 гишүүн санал ирүүлсэнтэй холбогдуулан Засгийн газраас баруун бүсэд энэ тэжээл гурилын импорттой холбоотой хөнгөлөлт чөлөөлөлтийн эрхийг Засгийн газарт өгөх тухай энэ тогтоолын төслийг өргөн мэдүүлснийг хэлэлцээд явж байгаа гэдгийг хэлье.

Ер нь бол цаашид бол өвөлжилтийн бэлтгэл хангах ажил бол хүн бүрийн л анхаарах ёстой зүйл. Иргэнээсээ эхлээд, малчнаасаа эхлээд төр хүртэл анхаарах учраас энэ зүйл дээр цаг алдахгүй урьдчилан төлөвлөж ирэх оны ажлыг өнөөдрөөс эхлэн төлөвлөж ингэж ажиллах болно оо гэдгээ энд илэрхийлье. Малыг гоц халдварт өвчнөөс сэргийлэх ажил бол чухал. Ялангуяа Мал эмнэлгийн ерөнхий газар дээр энэ асуудлаар бол тодорхой ажилтай танилцана. Ялангуяа энэ малын

вакциныг цаг хугацаанд нь буюу графикт хугацаанд бүрэн хийж хэрэгжүүлэх ажил хамгийн чухал байгаа.

Энэ дээр хугацаа алдсан ийм зүйлүүд бол бас байгаа юм байна гэдгийг урьдчилсан байдлаар танилцсан байгаа. Энэ ямар учир шалтгаанаар хугацаа алдсан бэ гэдгийг тодруулна хянана. Тэгээд эргэж Байнгын хороонд мэдээлэхэд бэлэн байна. Ер нь цаашдаа бол энэ мал эмчилгээ, үйлчилгээний хөлс энийг цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлэх, малчдад малын эм тариан талаар зөв мэдлэг олгох энд хяналтын ялангуяа малд хэрэглэдэг эм, тариан дээр онцгой, салбарын хяналт тавих асуудал гээд энэ асуудал дээр онцгой анхаарал хандуулж ажиллах болно оо гэдгээ хэлье ээ. Баярлалаа.

**Н.Наранбаатар:** Тодруулах уу? Мэндсайхан гишүүн. Тодруулъя.

**З.Мэндсайхан:** Би Бадамсүрэн сайд саяхан ажлаа авсан учраас би Бадамсүрэн сайдаас асуугаад байгаа юм биш. Энэ яамны нөхдүүдээс асуугаад байна л даа. Ямар шалтгаанаар та нар тэр усалгаатай газар тариалангийн баруун бүсийн тэжээлийн үйлдвэрийг алга хийчхэв ээ. Тэнд хувийн хэвшлүүд өөрсдөө тэжээлийн таримлаа тариад үйлдвэрт түүхий эдээ нийлүүлэхэд бэлэн болчихсон байна. Тэгээд та нар энийг яагаад алга хийчхэв. Тэр усалгаатай тариалангийн төслийг яагаад татан буулгачхав. Ховд аймагт хийх гэж байсан 2500 га усалгаатай газар тариалангийн тэр усалгаатай төслийг яагаад та нар татсан бэ? Энхбаяр сайд ямар шалтгаанаар татсан бэ? Энэ Дархан Сэлэнгэ, Ховдод хийх гэж байсан төслийг Дархан, Сэлэнгэ рүү татсан гэж яриад байгаа. Дархан, Сэлэнгэд энийгээ ажил болгосон уу? Болорчулуун дарга энэ дээр хариулт өгөөдөх.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн 4 номер хариулъя.

**Ц.Болорчулуун:** ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун Мэндсайхан гишүүний асуултад хариулт өгье. Тэгэхээр Ховд аймгийн Эрдэнэсүрэн суманд АХБ-ны санхүүжилттэй 2 мянган га-ийн услалтын системийг барьж байгуулах ийм төсөл хэрэгжүүлэхээр анх АХБ-ны 42 сая долларын санхүүжилттэй энэ төсөлд хамрагдаад энэ судалгаанууд зураг төсөл хийгдээд явсан. Зураг төсөл хийгдээд тендер сонгон шалгаруулалтыг 2 удаа зарлаад энд тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон. Ингээд цаашдаа бол энэ хөрөнгө оруулалтын тооцоод үзэхээр энэ дээр нийтдээ 7 сая гаруй доллароор энэ төсөл хэрэгжихээр байсан. Тэгээд эдийн засгийн хувьд үр ашиг багатай гэдэг байдлаар энэ төсөл бол ингээд зогсоогдсон байгаа гэдгийг хэлье.

Зүгээр Дэлхийн банкны санхүүжилтээр Ховд аймгийн төв дээр энэ Буянт суманд тэжээлийн үйлдвэр баригдаж байгаа. Энэ нь бол 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа.

**Н.Наранбаатар:** Гүйцээж хариулъя. 4 номер.

**Ц.Болорчулуун:** АХБ-ны санхүүжилтээр хэрэгжихээр байсан Эрдэнэбүрэн сумын энэ усалгаатай газар тариалангийн энэ төслийг дахин бид авч хэлэлцэж үзээд шаардлагатай тохиолдолд дахиж АХБ-нд хүсэлт гаргуулаад эргэж харах боломж нь байгаа гэж харж байна.

**Н.Наранбаатар:** Мэндсайхан гишүүн тодруулъя. АХБ-ны олон улсын экспертүүд судалгаа хийгээд гаргаж ирээд энэнд ийм хэрэгцээ шаардлага байна аа. Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай аймгийг малын тэжээлээр хангахад тариалангийн бүс нутаг нь Ховд аймгийн энэ Ховд голын дагуух энэ сав бүс нутаг байна аа гэж үнэлгээ хийгээд гаргаад ирж байхад хэн тэрийг эдийн засгийн ач холбогдолгүй гэж шийдвэрийг хүчингүй болгосон бэ? Энийг хэлээд өг дөө.

**Н.Наранбаатар:** 4 номер хариулъя.

**Ц.Болорчулуун:** Энэ төсөл бол Энхбаяр сайдын урд нөгөө Болорчулуун сайдын үед энэ төсөл яригдаад явж байгаад 2 мянган га газарт усалгаатай газар тариалан эрхлэх, тэнд тэжээлийн таримал болон хүнсний ногоо тариалах ийм төсөл байсан. Тэгээд энэ бол тэр үед яригдаад 2 мянган га-д бол энэ төсөл төсөвт өртгөө нөхөх хугацаа нь бол маш удаан байна аа энэ боломжгүй байна аа гээд мянган га болгож багасгасан байгаа юм. Ингээд мянган га болгож багасгаад.

Энэ яаман дээр ярьж тэр төслийн ерөнхийдөө төсөвт өртөг нөхөх хугацааг нь л тооцож үзээд л тэгж гарсан шийдвэр. Бид нар төслийн багийн төслийн төсөл хэрэгжүүлэх нэгж байгаа.

**Н.Наранбаатар:** Гүйцээе. Тодорхой хариулъя.

Төсөл хэрэгжүүлэх нэгж энэ дээр тусдаа энэ АХБ-ны төслийг хэрэгжүүлж ажилладаг. Төсөл хэрэгжүүлэгч нэгж дээр бол зөвлөхүүд ажилладаг. Энэ зөвлөхүүдийн тооцоолол дээр үндэслээд хэдий хугацаанд энэ төсөвт өртгөө нөхөх вэ гэдгийг тооцоолж гаргаад энэ нөхөх хугацаа нь тэнд тэжээлийн таримал тарьснаар удаан байна гэдэг байдлаар га-ийн хэмжээ эхний ээлжид багассан. Дараа нь бол ирээд ингээд мянган га-аар төлөвлөсөн байсан ажил бол ингээд зогсоосон байгаа. Сайдын шийдвэрээр.

**Н.Наранбаатар:** Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

**Д.Батбаяр:** Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийнх нь энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд намрын чуулган эхлээд явж байхад Жангабыл гишүүн анх санаачилж манай өрөөгөөр орж ирж байсан. Тэгээд энэ тогтоолын төсөл дээр тэгээд ХАА-н салбар тэр дундаа газар тариалангийн салбар энэ жил нэлээн алдагдалтай ажиллаж байна аа, хаа сайгүй ган гачигтай байна аа гэдэг үүднээсээ Жангабыл гишүүний саналыг дэмжиж энэ тогтоолын төсөлд дэмжиж гарын үсэг зурж байсан юм. Яг газар тариалангийн гол бүс нутгуудад энэ жил зуншлага тун тааруу болсон. Энэ утгаараа зөвхөн баруун бүс биш нийт Монгол орны даяар ер нь яг энэ түүхий манай гурилан бүтээгдэхүүний гол түүхий эд болсон энэ хөрөнгө газар тариаланг мөн малын тэжээлийг ингээд хамтад нь бүхлээр нь одоо гаалийн татварыг тэглэнэ ээ гэсэн ийм ойлголттой байсан. Тэгээд тогтоолын төсөл маань зөвхөн нөгөө тэжээлийн тариа, тэжээлийн арвай, овьёос, тэгээд зөвхөн баруун бүс буюу Баян-Өлгий аймгийн Цагаан нуур, Ховдын Ярант, Увсын Боршоо, Завханы Арц суурь, Говь-Алтайн бургастай гээд ингээд ороод ирж байгаа байхгүй юу.

Мэдээж баруун бүс дээрээ ялгаатай бүс болгон дээрээ ялгаатай бодлого баримтлах нь зүйтэй. Гэхдээ нийт улс орныг хамарсан энэ ган гачиг болж байна. Газар тариалан бол зөвхөн энэ Архангай, Өвөрхангай аймгаас бусад газруудад бол ургац алдчихсан, Төв, Сэлэнгийн бүсэд аймгуудад ургац алдчихсан. Тэгэхээр яг энэ

тогтоолынхоо төсөлтэй хамт зэрэгцүүлээд яг энэ гурилын үйлдвэрүүдийн үндсэн түүхий эд болсон энэ буудайг оруулж ирэх дээр энэ гаалийн татварыг нь хөнгөлж болоогүй юм уу. Энэ чинь үйлдвэрүүд чинь бүгдээрээ төвийн бүсэд байгаад байгаа. Түүхий эд чинь бүгдээрээ түүхий эдээ төмөр замаараа татах нь илүү хямдралтай их хэмжээгээр татах боломжтой.

Тэгэхээр хойд энэ боомтоороо боомтоо энд орхичихсон байгаад байх юм. Гол буудай чинь Оросоос оруулж ирж байгаа буудайг чинь тэр хойд галт тэргээр л оруулж ирнэ шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ яагаад энэ Сэлэнгэ аймгийн боомтуудаа хаячхав аа сайд аа. Уг нь бол зөвхөн баруун бүс гэхгүйгээр төвийн бүсийг л дэмжиж ингэж явна гэж л ойлголттой байсан юм.

**Н.Наранбаатар:** Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Бадамсүрэн сайд хариулъя. 5 хувийн татвартай л байгаа.

**М.Бадамсүрэн:** 1 дүгээрт буудай, одоогийн импортын татвар бол 5 хувь байгаа.

Хоёрдугаарт буудайг татварыг нь тэглэх, иргэд татвар тавих нь бол ийм тогтвортой бодлого биш ээ гэж салбарын хувьд үздэг юм байна. Тийм учраас энэ удаа зөвхөн баруун бүсэд буюу 1999 онд Улсын Их Хурлын гаргасан тогтоолын хүрээнд тухайн боомт зааж буюу тухайн орон нутгийн онцлогийг харгалзаж татварыг хөнгөлөх, чөлөөлөх эрхийг Засгийн газарт олгох тухай энэ Улсын Их Хурлын 1999 оны тогтоолын дагуу энэ үндсэн зарчмынх нь дагуу л баруун бүсэд энэ удаад гурил тэжээлийг импортын татварыг тэг хүртэл хувь тогтоох эрхийг нь Засгийн газарт олгож байгаа. Ийм л нэг удаагийн шинж чанартай зохицуулалттай байж болно. Энэ маань өөрөө хугацаатай.

Өөрөөр хэлбэл ирэх хавар, ирэх зун хүртэл үргэлжлэх ийм хугацаатай ийм тогтоол гэдгээрээ онцлогтой байгаа юм аа.

**Н.Наранбаатар:** Батбаяр гишүүн тодруулъя.

**Д.Батбаяр:** Тэрийг бол ойлгоод байна л даа. Цаг хугацааны хувьд мөн байршил заагаад ингээд нэг удаа шийдчихээд нэг удаа үйлчилж байгаа ийм тогтоолын төсөл гэдгийг ойлгоод л байна л даа. Тэгэхдээ яг энэ орж оруулж ирж шаардлагатай хэмжээтэй оруулж ирж байгаа энэ тэжээл чинь ихэнх нь энэ төмөр замаар орж ирнэ шүү дээ. Зөвхөн баруун бүсэд зөвхөн үнэ тэжээлийн үнэтэй биш байгаад байгаа юм. Яг энэ хойд төмөр замаа дагаад эндээс чинь ингээд нийт улс орон даяар дарна шүү дээ энэ тэжээл.

Тэгэхээр яг энэ Засгийн газрын хийж байгаа үйл ажиллагаа зөвхөн ганц бүсэд ч юм уу энд чиглэх ёсгүй гэж л би хараад байгаа байхгүй юу. Зүүн бүсэд, говьд төвийн бүсэд бас ажил амьдрал өрнөж байгаа. Тэгээд бүгдэд нь ижил тэгш явах ёстой биш юм уу? Нөгөө яг энэ тогтоолынхоо төсөл дээр жишээлбэл Сэлэнгэ аймгийн боомтын нэр чинь юу билээ айн? Алтанбулаг боомт гээд ингээд оруулчихвал яадаг юм? Болох уу?

**Н.Наранбаатар:** Бадамсүрэн сайд хариулъя.

**М.Бадамсүрэн:** Тийм яах вэ 1 дүгээрт нөгөө анхны хэлэлцүүлэг маань явагдсан байгаа. Зарчмын зөрүүтэй саналууд гарчихсан.

Хоёрдугаарт анх үзэл баримтлал нь бол Баруун бүсийн 5 боомтоор гэж өргөн мэдүүлээд тэгээд үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Улсын Их Хурал дэмжээд явж байгаа ийм зохицуулалт байгаа.

Хоёрдугаарт таны саналтай санал нэг байгаа зүйл нь ер нь цаашид Монголын малчдад үндсэндээ малд нь бол бэлчээрийн хомсдолтой холбоотойгоор үүдэлтэйгээр 1 дүгээрт тэжээл, 2 дугаарт нь аль болох битүү хашаа хороо буюу ийм дулаан аль болох алдахгүй байх ийм 2 нөхцөлийг бүрдүүлэх чиглэл рүү манай салбараас МАА-н салбарт баримтлах бодлого дээр гол анхаарлаа хандуулна аа гэж бид төлөвлөж байгаа. Ялангуяа цаашид ирээдүйд бол ОХУ-ын энэ газар тариалангийн бүс нутгаас тэжээлийн будаа импортолж Монголын одоо.

**Н.Наранбаатар:** Сонгобайн Замира гишүүн асуулт асууна.

**С.Замира:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ гурилын татварын асуудлыг Энхбаяр сайд нэлээд хөөцөлдөж байж ингээд батлуулсан л даа. Бид нарт тайлбарлаж ярьсан. Тэгэхдээ ингээд өвлийн хүйтэнд дахиад энэ гурилын асуудал ороод ирж байна. Жангабыл гишүүний санаачилгаар нэлээд хэдэн гишүүд гарын үсэг зураад өчнөөн сар өнгөрлөө. Өвлийн хүйтэн болж байна. Байнгын хорооны тогтоол өнөөдөр баталлаа гэхэд энэ хэзээ Их Хуралд орох вэ? Хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ гэдэг товч бөгөөд тодорхой асуулт асууя.

Бадамсүрэн сайд болохоор аймагт Засаг дарга хийж байсан хөдөө орон нутгийн асуудлыг нэлээд сайн судалсан, мэддэг, мэдэрдэг хүн. Тийм учраас нэлээд урагштай ажиллах байх аа. Хөдөө орон нутгийн юун дээр нэлээд санаа оноо тавих байх аа гээд найдаж байна. Энэ асуулт дээр нэг тодорхой хариу өгөөч.

**Н.Наранбаатар:** Бадамсүрэн сайд хариулъя.

**М.Бадамсүрэн:** Замира гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурал өнөөдөр хэрвээ хамтарсан Байнгын хороо дэмжээд эцсийн хэлэлцүүлэгт Улсын Их Хурал руу шилжүүлсэн тохиолдолд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаан энэ 5 дахь өдөр буюу нөгөөдрийн хуваарь дээр энэ асуудлыг хэлэлцэж батлахаар байгаа. Энэ 5 дахь өдөр хэрвээ Улсын Их Хурал энэ тогтоолыг өөрчлөлтийг баталбал ирэх 7 хоногийн лхагва гаргийн Засгийн газрын хуралдаанаар бид танилцуулна. Гэхдээ энд Ерөнхийлөгчийн хориг тавих бас хуулийн хугацаа байгаа.

Хэрвээ яаравчилна гэж үзвэл энийг Ерөнхийлөгчийн институцээс хориг тавих эсэхийг урьдчилж лавлаж тэгээд ирэх 3 дахийн Засгийн газрын хуралдаанд хэрвээ эс үгүй бол хоригийн хугацаа дууссаны дараа Засгийн газрын ээлжит бус хуралдаанд ч юм уу яаралтай шийдвэрлүүлэхээр бид саналаа өгч болно. Бид энэ тогтоолын төслөө манай яам Засгийн газрын тогтоолын төслийг ингээд бэлдчихсэн байгаа. Энэ тогтоолын төсөл дээр бол баруун 5 аймгийн 5 боомтоор 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр өдрийг хүртэл хугацаанд улаан буудайн гурил малын тэжээлийг тэг хувийн татвартайгаар импортлохоор өөрчлөн тогтоосугай гэсэн ийм тогтоолын төслийг санаачилчхаад

байгаа юм. Манай яам бэлтгэлээ хангачихсан. Их Хурал баталбал Засгийн газартаа шууд барихад бэлэн байгаа.

Өөрөөр хэлбэл нөгөө Засгийн газарт Улсын Их Хурлаас эрх өгч байгаа учраас Засгийн газар шийдвэрээ шуурхай гаргах тэр зүйл рүү онцгой анхаарч байгаа гэдгийг танд хэлье. Баруун бүсээр энэ 2025 онд оруулж ирсэн тэр дүнг харгалзан үзэж импортоор оруулж ирсэн дүнг харгалзан үзэж энэ дээр баруун бүсэд ийм хэмжээний гурил, тэжээлийг импортоор оруулах боломжтой юм байна аа. Ийм төсөөлөлтэй байгаа юм байна аа гэдгийг урьдчилан тооцсон байгаа. Яах арга байхгүй баруун бүс бол үнэхээр онцлогтой юм байна лээ. Сая Мэндсайхан гишүүн ч гэсэн хэлсэн.

Тэр бүсийн тариалалтыг тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, малчдыг тэжээлээр иргэдийг гурилаар хангахын тулд баруун бүсэд зайлшгүй тусдаа онцгойлсон. Ийм бодлогын арга хэмжээ авахгүй бол болохгүй юм байна лээ. Манайх чинь бүсчилсэн хөгжил гээд үзэл баримтлалтай.

Дээр нь Монгол Улс нөгөө нэгдмэл улс хэдий ч гэсэн зөвхөн нэг аймгийн нутаг нь гэхэд нийт улс орнуудын нутаг, ихэнх улс орны нутаг дэвсгэрээс том өөрөө ийм хангайн бүс, говийн бүс, талын бүс гээд ийм олон онцлогтой учраас гарцаа байхгүй цаашдаа энэ бүсийн онцлогт тохирсон уян хатан ийм ХАА-н салбарын дэмжлэгийн бодлого бол хэрэгжүүлэх нь зайлшгүй юм байна аа гэдэг нь энэ гурилын импортын, тэжээлийн импортын татварын зохицуулалтаар харагдаж байгаа гэдгийг би Байнгын хорооны эрхэм гишүүддээ цаашид манай салбарын ажлыг дэмжихэд энэ дээр онцгой анхаарч дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа за.

**Н.Наранбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.2-т хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эс үгүй бол бусад хуультай зөрчилдсөн талаар хууль зүйн зөвлөмжийг ХЗБХ дэмжиж санал, дүгнэлт гаргасан бол тухайн асуудлаар санал хураалт явуулж болно гэсэн заалтыг үндэслэн санал хураалт явуулна аа.

Санал хураалт явуулахаас өмнө ХЗБХ-оос ирүүлсэн санал, дүгнэлтийг танилцуулъя.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хууль зүйн зөвлөмжийг хэлэлцсэн талаар ХЗБХ-ны санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын Тамгын газраас 2025 оны 12 сарын 9-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Хууль зүйн зөвлөмжийг гаргаж, Төсвийн болон БОХХАА-н байнгын хороонд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 сарын 9-ний өдрийн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Төсвийн болон БОХХАА-н байнгын хороонд хүргүүлж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар Хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын Тамгын газрын байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа танилцуулсан болно оо.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар гаргасан хууль зүйн зөвлөмжийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар.

Санал хураалт явуулъя аа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе ээ.

Батбаяр гишүүн ороогүй байна орчихсон гэж байна.

Хэн ороогүй байгаа юм?

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42-ын дүгээр зүйлийн 42.2.2 дахь заалтыг үндэслэн хураах санал.

1.Төслийн 5 дахь заалтыг хасах.

Санал гаргасан. Төсвийн болон БОХХАА-н байнгын хороо.

Санал хураалт.

58.1 хувиар дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон БОХХАА-н байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан танилцуулна.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсэгт баярлалаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан энэ танхимдаа үргэлжлэн хуралдах тул дараагийн хуралдааны ирцийг. Үүсгэнэ үү.

11.47 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА